BE ALWAYS CONNECTED WITH YOUR LAWYER

ALISON& KATE
PARTNERS

LEGAL NEWSLETTER

2026.10.27 №73 AKP Law Firm

Бид 2026 оны 10 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх батлагдсан онцлох тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна.

I. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1.1 Зохиогчийн Эрхийн Тухай Хууль Үндсэн Хууль Зөрчсөн Талаар:

Үндсэн хуулийн Цэц 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдөр дунд суудлын хуралдаанаар Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15.2 дахь хэсэг Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай хянан хэлэлцсэн. Тус заалтад хамтран бүтээл туурвисан зохиогчдын бүтээл ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхэлж үүснэ гэж заасан. Цэц энэхүү заалтыг өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах, зохиогчийн туурвисан оюуны үнэт зүйлийг түүний өмч байх, хөрөнгийг өмчлөх, өвлүүлэх эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн 5.2, 7.2, 16.3, 16.8 зүйлүүдийг зөрчсөн гэж үзжээ. УИХ 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр хуралдан уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх тогтоол баталж, тус хэсгийг өөрчлөхөөр боллоо.

II. ЗАСГИЙН ГАЗАР: ОНЦЛОХ ТОГТООЛ

2.1 Томуутай Холбоотой Ажилтанд Олгох Цалинтай Чөлөөний Талаар:

2026 оны 11 дүгээр сарын 1-ээс 2027 оны 3 дугаар сарын 1 хүртэл томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдийн асран хамгаалагчид ажлын 5 хүртэлх өдрийн цалинтай чөлөө олгох, эсхүл зайнаас ажиллуулахыг төрийн албаны ажил олгогч нарт даалгаж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажил олгогч нарт уриалсан.

2.2 Түлшний гаалийн татварын тэглэсэн талаар:

Замын-Үүд, Булган, Шивээхүрэн боомтоор импортолж буй 92 октантай автобензин болон дизелийн түлшний гаалийн албан татварыг 2028 оны 12 дугаар сарын 31 хүртэл 0 хувиар тогтоолоо. Тогтоолыг 2026 оны 10 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан бөгөөд Бүсийн хөгжлийн бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан гэж тайлбарласан байна. Үүнээс өмнө Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд 90-ээс дээш октантай нэг тонн автобензин, дизелийн түлшинд 25,700 төгрөг ноогдуулахаар заажээ.

2.3 Орон Сууцны Залилах Гэмт Хэргээс Сэргийлэх Талаар:

Барьж дуусаагүй байгаа барилгын байр, талбайг олон хүнээс зэрэг захиалгаар авч, залилах эрсдэлээс сэргийлэх, иргэдийг хохироохгүй байх үүргийг холбогдох албан тушаалтнуудад өгсөн байна. Зөвшөөрөлтэй баригдаж буй нийтийн орон сууцны мэдээллийг төрийн байгууллагууд хоорондоо цахимаар солилцож нээлттэй, тодорхой мэдээлдэг систем бүрдүүлэхээр зорьж байна.

2.4 Суурь Тэтгэврийн Дээд Хэмжээг Өөрчлөн Тогтоосон Талаар:

УИХ-аас батлагдсан төсвийн тодотголоор Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, ахмад настнуудаа 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс суурь тэтгэвэр олгох нөхцөл бүрдсэн. Ийнхүү 2026 оны 10-р сарын 21-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3.6 дах хэсэгт “Суурь тэтгэврийн

үндсэн дүнг 100,000 төгрөг, суурь тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүнг 40,000 төгрөг, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүнг 5,000 төгрөг, суурь тэтгэврийн дээд хэмжээг 300,000 төгрөгөөр тогтоож, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах тухай тогтоолыг баталсан. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлага, суурь тэтгэврийн хэмжээг тооцох томьёо болон тогтоолд заасан үзүүлэлтүүдийг баримтлан суурь тэтгэврийн хэмжээг тооцож, хуульд заасан хугацаанаас эхлэн олгохоор болов.

III. УИХ-ААС ТОМИЛОГДДОГ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛТНЫ ШИЙДВЭР

3.1 Төлбөрийн Системийн Журам

Монгол банкны ерөнхийлөгчийн тушаалаар Монголбанк төлбөр тооцооны системийг чангаруулж, үндэсний төлбөрийн системийн аюулгүй, тасралтгүй байдлыг хангах үүднээс шинэ журам баталлаа. Энэхүү журмаар Төлбөр тооцооны гол "Банксүлжээ систем"-ийг зөвхөн Төв банк ажиллуулах, Бидний өдөр тутам ашигладаг АТМ, дэлгүүрийн ПОС болон банкны салбар дахь ПОБ төхөөрөмжүүд гэх мэт цахим мэдээ үүсгэх, гүйлгээ хийх орчныг тус тус нарийвчлан тодорхойллоо.

3.2 Үнэт Цаасаар Гэрчлэгдсэн Өмчлөх Эрхийг Бусдад Бэлэглэл, Өв Залгамжлалаар Шилжүүлэх Тухай Журам

Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон Кастодиан банкнаас үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өв залгамжлуулах харилцааг шинэ журмаар зохицуулж байна. Мөн иргэдийн гаргах бэлэглэлийн ба өвлөх хүсэлтийн загвар, тайлагналын маягтуудыг иж бүрэн журамласан.

3.3 Банкны нягтлан бодох бүртгэлийн журам

Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг шинэчлэн баталж байгаатай холбогдуулан банкны санхүүгийн үйл ажиллагааг Олон Улсын Санхүүгийн Тайлагналын Стандартад нийцүүлэн хөтлөх, санхүүгийн хөрөнгийг үнэн зөв ангилан бүртгэхэд дагаж мөрдөнө.

IV. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-ИЙН ШИЙДВЭР:

Аймаг, нийслэлийн иргэний төлөөлөгчдийн хурлаас дараах шийдвэрүүдийг батлав:

- Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээг Дарханы дугаартай бол жилд 1 удаа, Бусад аймаг, хотын дугаартай бол Шалган бүртгэх товчоогоор нэвтрэх тухай бүр төлөх байдлаар тогтоов.
- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэн ховор, ховор, элбэг хэмээн хувааж Экологи эдийн засгийн суурь үнэлгээ болон Тогтоосон хувь хэмжээгээр тооцох төлбөрийг шинэчлэн тогтоов.
- Төв аймгийн Зуунмод сумд Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүс, Мал бэлчээрлүүлэхийг хориглох бүсийн координат болон Түр хадгалах, зардал нөхөн төлүүлэх журмыг баталлаа. Илрүүлсэн малыг баримтжуулан тусгай хашаанд хашиж, өвс тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд малын эзэн тогтоогдмогц тээвэрлэлт, маллагааны бүх зардлыг нөхөн төлүүлж, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцон буцаан олгоно. 3 хоногийн дотор эзэн нь ологдохгүй бол Цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

ALISON & KATE PARTNERS
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3 давхар, 301/а
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414